



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 712

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ:

1.Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй, 16 нэрийн, нийт 8,546,591.14 (найман сая таван зуун дөчин зургаан мянга таван зуун ерэн нэгэн төгрөг арван дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн захирал Б.Баяржавхлан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

133622910
30-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 1.2 дугаар сарын 18-ны өдрийн
712 дугаар тогтоолын хавсралт

ШУТИС-ИЙН ХАРЬЯА ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр, марк	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон он	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Компьютер Dell	ш	1	11/25/2012	362,780.00	362,780.00	-
2	Бар код уншигч	ш	1	11/13/2015	127,600.00	127,600.00	-
3	Оюутны ширээ	ш	32	9/30/2013	29,400.00	940,800.00	-
4	Шар ширээ	ш	8	3/30/2009	13,200.00	105,600.00	-
5	Оюутны ширээ	ш	30	8/17/2009	70,000.00	2,100,000.00	-
6	Сандал	ш	29	12/31/2012	59,000.00	1,711,000.00	-
7	Сандал	ш	1	10/30/2012	33,000.00	33,000.00	-
8	Саарал ширээ	ш	1	11/11/2021	36,000.00	36,000.00	-
9	Хар сандал	ш	4	1/1/2011	5,400.00	21,600.00	-
10	Оюутны сандал	ш	30	6/18/2009	28,000.00	840,000.00	-
11	Чарган хөлтэй сандал	ш	2	6/10/2010	19,523.07	39,046.14	-
12	Хүлээн авах тек	ш	1	12/31/2009	114,000.00	114,000.00	-
13	Дугуй ширээ	ш	6	12/31/2009	47,250.00	283,500.00	-
14	Уншлагын сандал	ш	35	12/28/2009	15,015.00	525,525.00	-
15	Уншлагын сандал	ш	38	12/28/2009	26,400.00	1,003,200.00	-
16	Хар сандал	ш	51	12/28/2009	5,940.00	302,940.00	-
	НИЙТ ДҮН		270			8,546,591.14 (найман сая таван зуун дөчин зургаан мянга таван зуун ерэн нэгэн төгрөг арван дөрвөн мөнгө)	-